

Төслийн ID/Дугаар: P130891

**МОНГОЛ УЛС: УХААЛАГ ЗАСАГ ТӨСӨЛ**

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2021 оны 4 дүгээр сар

## АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1. Төслийн танилцуулга.....	4
1.2. Төсөл хэрэгжүүлэх зохион байгуулалт .....	1
1.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, хамрах хүрээ .....	2
2. ХУУЛЬ ЭРХЗҮЙ, БОДЛОГЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ЗОХИЦУУЛАЛТ .....	3
2.1. Дэлхийн банкны хамгааллын бодлогууд .....	3
2.2. Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт.....	3
3. БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ БОЛОН БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД .....	15
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МОНИТОРИНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	18
5. МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХ, ЗӨВЛӨЛДӨХ, ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ .....	19
5.1 Мэдээллийг олон нийтэд танилцуулах, олон нийтийн хэлэлцүүлэг .....	19
5.2 Гомдлыг хянан шийдвэрлэх механизм .....	19
6. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ .....	23
6.1. Төслийн гүйцэтгэлийн явц.....	23
6.2 Байгаль орчны менежментийн хэрэгжилтийн зохицуулалт.....	23
6.3 Байгаль орчны тулгамдсан асуудлууд ба бууруулах арга хэмжээ.....	23
Хавсралт 1. Бага хэмжээний барилгын ажилд зориулсан байгаль орчны туршлагын дүрэм.....	27
Хавсралт 2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөсөн COVID-19–ын үед авах арга хэмжээ.....	34

## Товчилсон үгсийн тайлбар

БА	Бизнес аналитик
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ҮНДТ	Үндэсний нөөц дата төв
БОТД	Байгаль орчны туршлагын дүрэм
БОЭМХ	Байгаль орчин, эрүүл мэнд, хамгаалал
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
ePRS	Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн цахим систем
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ГХШМ	Гомдлыг хянан шийдвэрлэх механизм
ӨГБҮ	Өргөдөл гомдлыг барагдуулах үйлчилгээ
МХХТ	Мэдээлэл, харилцаа холбооны технологи
МХХДБХТ	Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлэх төсөл
МТШХХГ	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ҮДТ	Үндэсний дата төв
ТЭА	Төрийн энтерпрайз архитектур
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮАБ	Үйл ажиллагааны бодлого
ТХЗ	Төслийн хөгжлийн зорилго
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТУХ	Төслийн Удирдах хороо
АД	Ажлын даалгавар
ДБ	Дэлхийн банк
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ОУХА	Олон улсын хөгжлийн ассоциаци

## 1. ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн танилцуулга

Төслийн хөгжлийн зорилго нь мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-г ашиглан Монгол Улсын төрийн үйлчилгээний хүртээмж, ил тод байдал, үр ашгийг илүү сайжруулахад оршино.

Төсөл нь Монгол Улсын Ухаалаг засаглалын санаачилгыг дэмжих МХХТ болон нээлттэй өгөгдлийн экосистемийн бүрэлдэхүүн хэсгүүдтэй. Дараах 4 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

#### 1) Бүрэлдэхүүн хэсэг 1: Иргэний оролцоо, иргэдийн санал хүсэлтийн механизмын сайжруулах. Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь:

- Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх; Хөрөнгө оруулалтын дэмжлэг: (i) 11-11 төвийн системийг шинэчилж, тоног төхөөрөмжийг өргөтгөх, (ii) иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг нэгтгэж, мэдээллийг ач холбогдолтой байдлаар харуулах хяналтын самбарыг бий болгох, (iii) системд өргөдөл гомдлын дагуу хариуцлагыг сайжруулах загварчлалыг боловсруулах; (iv) системийн ерөнхий гүйцэтгэлийг сайжруулах үүднээс яамдаас хариу өгөх процессыг сайжруулах;
- Бодлого хөтөлбөрийн шийдвэр, гүйцэтгэлийг сайжруулах, оновчтой болгох өгөгдөлд дүн шинжилгээ хийх боломжийг олгох программ, хэрэгсэл, шилдэг туршлагаудаас бүрдэх бизнес аналитикийн программыг хөгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх.

#### 2) Бүрэлдэхүүн 2: Ухаалаг засаглалын суурийг бэхжүүлэх.

Бүрэлдэхүүн 2-ын бүрдэл хэсгүүд:

- Засгийн газрын хэмжээнд илүү сайн стратеги, үйл явц, төлөвлөгөө, бүтэц, технологи, системийг бий болгох зорилгоор Төрийн энтерпрайз архитектур (ТЭА), өгөгдөл солилцох нэгдсэн тогтолцоог (e-GIF)—ийг загварчлах, байршуулах, ашиглахад хөрөнгө оруулалт, техникийн туслалцаа үзүүлэх;
- Үндэсний дата төвийг шинэчлэх, төрийн мэдээлэл солилцох, үүлэн тооцоолох дэд бүтцийг бий болгоход хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;
- Засгийн газрын тэргүүлэх салбарын зорилтуудыг дэмжих үүднээс нээлттэй өгөгдөл, мобайл аппликэйшныг тодорхойлох, турших, ашиглах механизм бий болгох инновацийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;
- Улаанбаатар хотын 5 дүүрэг болон 8 аймагт хэрэгжсэн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийг цахим систем (ePRS)-ийг 9 дүүрэг, 21 аймагт (орон даяар) нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Ухаалаг засаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавхыг хөгжүүлэн бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

### **3) Бүрэлдэхүүн 3: Нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх.**

Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь:

- Нээлттэй өгөгдлийн санаачилгыг боловсруулан хэрэгжүүлэхэд дараах 4 чиглэлээр дэмжлэг үзүүлнэ. Үүнд i) нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээ; ii) бодлого, хууль эрхзүй, зохион байгуулалтын тогтолцоо; iii) нээлттэй өгөгдлийн нийлүүлэлт iv) эрэлтэд суурилан дахин ашиглах, хамтран бүтээх;
- Үндэсний статистикийн хорооны мэдээлэл боловсруулах чадавхыг бэхжүүлэх.

### **4) Бүрэлдэхүүн 4 Төслийн хэрэгжилтийг дэмжих.**

Төслийн үндсэн ашиг хүртэгчид нь илүү үр ашигтай, зардал багатай үйлчилгээг хүргэх төр; илүү сайжирсан төрийн үйлчилгээ авах, шийдлийг хамтран бүтээх хувийн хэвшил; илүү сайжирсан төрийн үйлчилгээг хүлээн авах иргэд болно.

#### **1.2. Төсөл хэрэгжүүлэх зохион байгуулалт**

ЗГХЭГ-ыг Монгол Улсын сайд тэргүүлдэг. Тус газар нь төслийн хэрэгжилтийг хариуцан ажилладаг бөгөөд үүнд ерөнхий зохион байгуулалт, үр дүнгийн хяналт-шинжилгээ, Дэлхийн банктай хийх харилцаа, хамтын ажиллагаа зэрэг багтана.

Ашиг хүртэгч байгууллага нь ЗГХЭГ, ХХМТГ, ҮСХ, УБЕГ болно. ХХМТГ, ҮСХ нь Олон улсын хөгжлийн ассоциацийн санхүүжилттэй төслийг хэрэгжүүлсэн туршлагатай. УБЕГ нь Мянганы сорилтын корпорацаас санхүүжүүлсэн төслийг хэрэгжүүлж байжээ.

Төслийн Удирдах хороо (ТУХ) нь төслийн үйл ажиллагаанд дараах чиг үүргийг хүлээдэг. Үүнд ерөнхий стратеги, бодлогын удирдамж, хяналт шинжилгээ, байгууллага хоорондын харилцаа зэрэг чиг үүрэг багтана.

ТУХ-г Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тэргүүлж, ашиг хүртэгч байгууллагын дарга нар, Сангийн яамны төлөөллөөс бүрдэж байна. ТУХ нь улирал бүр нэгээс доошгүй удаа хуралдана. ЗГХЭГ-ын Технологийн удирдах ажилтан нь төслийг хариуцаж ажиллах бөгөөд төслийн Удирдах хорооны гишүүн, төслийн захирал байна. Төслийн зохицуулагч нь ТУХ-ны нарийн бичгийн дарга байна.

Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) нь төслийн хэрэгжүүлэхэд ерөнхий менежмент, санхүүгийн удирдлага, хяналт, үнэлгээ, тайлагналт зэргийг хариуцан ажилладаг. Ашиг хүртэгч байгууллагуудад дэмжлэг үзүүлэн ажилладаг. Төслийн зохицуулагч ТХН-ийг удирдах бөгөөд ТХН дараах ажилтнуудаас бүрддэг. Үүнд: санхүүгийн мэргэжилтэн, худалдан авах ажиллагааны мэргэжилтэн, мэдээлэл харилцааны мэргэжилтэн-орчуулагч, хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн. ЗГХЭГ нь ТХН-ийн дагаж мөрдөх Төсөл хэрэгжүүлэх журмыг боловсруулж, баталжээ. Уг журам ТХН-ийн чиг үүрэг, үйл ажиллагааны систем, дүрэм журам (ТХН-ийн зохион байгуулалтын бүтэц, оффисын үйл ажиллагаа, журмууд), санхүү, нягтлан бодох бүртгэлийн журам (хөрөнгийн урсгал, зарцуулалтын зохицуулалт), худалдан авах ажиллагааны журам зэргийг оруулжээ.

ТХН нь гуравдагч талын зөвлөхүүд эсвэл барилга байгууламжийн ажлын гүйцэтгэгчдийн БОТ-ний хэрэгжилтийг ерөнхийд нь хариуцна хэмээн төлөвлөж байна. ТХН нь (i) бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх явцдаа барилга байгууламжийн ажил гүйцэтгэгчдийн анзааргагүй байдлыг хянах; (ii) барилга байгууламжийн ажлын гүйцэтгэгчид, орон нутгийн удирдлагатай холбоо тогтоож, төслийг хэрэгжүүлэх явцтай холбогдон гарах байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг туслалцааг авах (iii) аливаа гомдол санал, осол эндэгдэл, үл нийцлийг мэдсэний дараа нэн даруй БОТ-ний хагас жилийн хэрэгжилтийн нөхцөл байдлын талаар Дэлхийн Банканд тайлагнах үүргийг хүлээнэ.

### **1.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго, хамрах хүрээ**

Энэхүү Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г төслийн бүрэлдэхүүн хэсгүүдэд хийсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд үндэслэн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг бууруулах хэрэгсэл болгон бэлтгэсэн болно. Тодруулбал, БОМТ нь хүрээлэн буй орчны сөрөг нөлөөлөл, эрсдэлийг арилгах, нөхөн тооцох, эсвэл хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулах зорилгоор төсөл хэрэгжүүлэх, үйл ажиллагааны явцад хэрэгжүүлэх арга хэмжээний багцыг бууруулах, хянах, зохион байгуулах арга хэмжээнээс бүрдэнэ. БОМТ нь хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг багтаасан болно.

## **2. ХУУЛЬ ЭРХЗҮЙ, БОДЛОГЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ЗОХИЦУУЛАЛТ**

### **2.1. Дэлхийн банкны хамгааллын бодлогууд**

Дотоодын түншийн санхүүжилтээр Үндэсний нөөц дата төвийг байгуулах, ашиглалтад оруулах дэд төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бага хэмжээний барилгын ажлыг хамарсан тул Байгаль орчны үнэлгээний бодлогын баримт бичиг “Дэлхийн банкны Үйл ажиллагааны бодлого (ҮАБ) 4.01”-ийг хангах шаардлага үүсч байна. Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл нь түр зуурын шинжтэй, зөвхөн байршилд хамаарах, нөхөн сэргээгдэх шинжтэй тул В ангилалд хамруулсан болно.

Дэлхийн банкны ҮАБ 4.01 уугуул иргэдийн талаар баримтлах бодлого нь үндэстний цөөнхүүд төслийн үр шимийг хүртэгчид байгаа эсвэл байж болзошгүй тул уг төслийн хүрээнд мөн мөрдөгдөж байна. Гэсэн хэдий ч тодорхой хамгаалалтын хэрэгслийг шаардахгүй. Төслийн үйлчилгээг үзүүлэхдээ уугуул иргэдийн хэлийг ашиглан соёлын зохистой төслийн үр өгөөжийг хангах; төслийн сонгосон хэсгүүдийн уугуул иргэдийн тооцоолсон тоо, үйлчилгээ, мэдээлэл авах боломжтой уугуул иргэдийн эзлэх хувь хэмжээг тогтоох зэргээр төслийг боловсруулахад уугуул иргэдийн бодлогын холбогдох элементүүдийг шууд уялдуулах болно.

Нэмж дурдахад Дэлхийн банк группийн Байгаль орчин, эрүүл мэнд, хамгааллын (БОЭМХ) ерөнхий удирдамжийг төсөлд хамааралтай гэж үзэв.

### **2.2. Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалт**

**Хууль эрх зүй:** Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх байгаль орчны эрх зүйн баримт бичгүүдийг дор дурдсан бөгөөд эдгээр нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний салшгүй хэсэг юм. Иймд дараах хууль эрх зүйн баримт бичиг болон холбогдох бусад баримт бичгүүдийг хэрэгжүүлэх нь төсөл хэрэгжүүлэгчийн хамрах үндсэн үүргүүдийн нэг байх болно. Төсөлд хэрэгжүүлэгчийн дагаж мөрдөх ёстой байгаль орчны үндсэн хууль тогтоомжийг дор авч үзнэ.

Экологийн эрх зүйн шууд эх сурвалжтай хуулиудад, тухайлбал, төслийн үйл ажиллагаа, үнэлгээний ажилтай шууд холбоотой байгаль орчны асуудлаар дараах тусгай хуулиудыг багтаасан болно. Үүнд:

- Газрын хэвлийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 1995;
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2005;
- Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2006;
- Хог хаягдлын тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2007;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2008;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2008;
- Соёлын тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2008;
- Газрын төлбөрийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2009;
- Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2009;
- Байгалийн ургамлын тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2010;
- Байгалийн ургамлын хамгааллын тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2011;
- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2011;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2011;

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2012;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2012;
- Агаарын тухайн хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2012;
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2012;
- Усны тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2012;
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2012;
- Байгалийн нөөц ашиглалтын төлбөрийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2012;
- Ойн тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2012;
- Газрын тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2012;
- Хөрс хамгаалал, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, 2012;
- Амьтны тухай хууль, шинэчилсэн найруулга 2012;
- Ашигт малтмалын тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2012;
- Галын аюулгүй байдлын тухай хууль, шинэчилсэн найруулга 2015;
- Гамшгаас хамгаалах тухай хууль, 2012;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, шинэчилсэн найруулга 2020;
- Нийгмийн халамжийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2018;
- Эрүүл мэндийн тухай хууль, нэмэлт өөрчлөлт оруулсан 2019

**Байгаль орчныг хамгаалах тухай хууль** нь Монгол орны байгаль орчин, байгалийн нөөцийн бүхий л хуулийн гол үндэслэл болдог. Уг хуульд байгаль орчны үнэлгээ, байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны төлөв байдлын хяналт-шинжилгээний талаар авч үзсэний дагуу байгаль орчны асуудлыг шийдвэрлэж байх нь чухал юм. Энэ хуульд газар, түүний хөрс, газрын хэвлий, түүний баялаг, ус, ургамал, амьтан, агаар орчинд хортой нөлөөлж болзошгүй үйл ажиллагаанаас хамгаалж, байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлнэ гэж заасныг мөрдөх хэрэгтэй гэж заасан байдаг.

- Хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино. Энэ нь экологийн тэнцвэртэй нийгэм, эдийн засгийн хөгжил, хүрээлэн буй орчныг өнөөгийн болон ирээдүй хойч үедээ хамгаалах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах, түүний дотор газрыг нөхөн сэргээх, газар, хөрсийг экологийн сөрөг нөлөөллөөс хамгаалах зорилготой юм.
- Хуулийн 7-р зүйлд төсөл хэрэгжүүлэгчид хүрээлэн буй орчны байгалийн байдлыг хадгалахын тулд байгалийн нөөцийн үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ), 10-р зүйлд төсөл санаачлагчид хүрээлэн буй орчны төлөв байдал, өөрчлөлтөд байгаль орчны хяналт шинжилгээ хийхийг шаарддаг.
- Байгаль орчныг хамгаалах тухай хуульд (2012) оруулсан хамгийн сүүлийн нэмэлт өөрчлөлтөөр бохирдуулагчдын байгаль орчин, байгалийн баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөрийг төлөх хариуцлагыг тогтоожээ. Нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирол амссан байгалийн нөөцөөс хамаарна.

**Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зорилт нь** хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг



нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Дараах хүснэгтэд төслийн үйл ажиллагаатай холбоотой дагаж мөрдөх ёстой хуулийн заалтыг нэгтгэн харуулав.

### Хуулийн дагуу хэрэгжүүлэх заалтууд

Хуульд нийцэж буй байдал, хэрэгжүүлэх арга хэмжээ	Хуулийн заалтын дугаар
<b>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль</b>	
Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хийлгэнэ.	6.1, 7.3, 8.3, 9.1
Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл авна.	9.3
Байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.	9.9
Төслийн нөлөөллийн үнэлгээтэй холбогдол бүхий баримт бичгийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргаж өгөх; байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах	14.1.1, 14.1.2
Олон нийтийн оролцооны асуудлыг Засгийн газрын журмын дагуу хэрэгжүүлэх	18.4, 18.5
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэлгүйгээр үйл ажиллагаа явуулах, үнэлгээний шаардлага биелүүлээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй бол холбогдох торгуулийн арга хэмжээ авагдах	19.1, 20.1
<b>Байгаль орчныг хамгаалах тухай хууль</b>	
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг өөрийн зардлаар хийлгэх	7.1, 7.2
Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх; стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх; хог хаягдлын хэмжээг бүртгэж, багасгах, цэвэрлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, зогсоох болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх, байгаль орчинд хохирол учруулж болох аливаа үйлдлээс татгалзах	31.1-31.9
Байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх	40.1
<b>Байгалийн нөөцийн ашигласны төлбөрийн тухай хууль</b>	

Төсөл хэрэгжүүлэгч өөрөө байгалийн ус олборлож ашиглах тохиолдолд усны нөөц ашигласны төлбөр төлөх, уг төлбөрөөс байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулах	15.1, 15.3, 18.1
<b>Газрын тухай хууль</b>	
Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зориулалтаар газар эзэмших эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь 90 хоногт багтаан байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэсний дараа тэдгээртэй газар эзэмших гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, улсын бүртгэлд бүртгэнэ.	34.2
Хэрэв тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрхийн гэрчилгээгээр эзэмших газарт хийсэн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр сөрөг дүгнэлт гарсан бол эрхийн гэрчилгээг олгохоос татгалзаж, дуудлага худалдааны үнийг буцаан олгоно.	34.3
Газрын төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх	35.3.3
Газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцах;	50.1.1
<b>Газрын төлбөрийн тухай хууль</b>	
Газрын төлбөрийг түүний суурь үнэлгээнээс эзэмшиж, ашиглаж байгаа хот, тосгон, бусад суурины нэг га газрын төлбөрийн хязгаар 0.1-1.0 хувь;	7.1
Газрыг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн болон байгаль орчинд ивээлтэй технологиор ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газрын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.	8.1.2
Газрын төлбөрийн орлогыг аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт оруулна.	10.1
<b>Агаарын тухай хууль</b>	
Агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах;	9.1.2
Зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах болон хог хаягдал устгах стандартын шаардлага хангаагүй аливаа үйл ажиллагааг хориглоно.	20.6
<b>Усны тухай хууль</b>	
Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоо метр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоо метр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана.	28.4
Энэ хуулийн 28.4-т заасан дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг хоногт 100 шоо метрээс их ус ашиглах тохиолдолд сав газрын захиргаа, хоногт 50-100 шоо метр ус ашиглахад аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хоногт 50 шоо метрээс бага ус ашиглахад сум, дүүргийн Засаг дарга олгож, усны мэдээллийн санд бүртгэнэ.	28.6
Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны нөөцийг гэрээний үндсэн дээр хамтран ашиглаж болно.	28.12
Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно.	28.18
Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай тухайн ус хангагч байгууллага, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс хангагдаж байгаа ус ашиглагчтай сав газрын захиргаа, аймаг,	29.1

нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна.	
<b>Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль</b>	
Ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал уснаас төлбөр авах Засгийн газрын журмыг мөрдөх	4.5
<b>Байгалийн ургамлын тухай хууль</b>	
Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, хөнөөлт шавж болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ.	7.1
<b>Хог хаягдлын тухай хууль</b>	
Энэ хуулийн 9.1.3-т заасан журмын дагуу энгийн хог хаягдлаа ангилан ялгах;	10.2.1
Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх	10.2.2
Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах,	10.2.3
Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх;	10.2.4
Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;	10.2.5
Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох;	10.2.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;	10.2.7
Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх;	10.2.8
Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;	10.2.9
Энэ хуулийн 9.4.12-т заасан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;	10.2.10
Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах;	10.2.11
Хог хаягдлын талаарх сургалтад хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлэх;	10.2.12
Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах;	10.2.13
Хог хаягдлын талаарх хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;	10.2.14
Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх	10.2.15
Аж ахуйн нэгж, байгууллага нь байгууллагын ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;	10.2.16
Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад шилжүүлэх, эдгээр үйл ажиллагаатай холбоотой гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих,	10.2.17

байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх;	
Аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах.	10.2.18
Нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаяхыг хориглоно	10.3.1
Хог хаягдлыг ил задгай шатаах, хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаяхыг хориглоно	10.3.3, 10.3.5
Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулахыг хориглоно;	10.3.6
<b>Соёлын өвийг хамгаалах тухай хууль</b>	
Соёлын өвийг нээж, илрүүлсэн байгууллага, иргэн тухайн нутаг дэвсгэрийн бүртгэл, мэдээллийн санд 15 хоногийн дотор мэдэгдэж, анхан шатны бүртгэл хийлгэнэ.	23.1
Урьдчилан хайгуул судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг захиалагч хариуцна.	27.9
Олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тухайн сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.	30.4

### 2.3. Үндэсний стандартууд:

MNS нь агаар, дуу чимээ, ус, хөрсний чанар, үйлдвэрлэлийн хаягдал, бохир ус, бохирдуулах бодисын ялгаралтын орчны болон хаягдлын зөвшөөрөгдөх стандартыг тогтоодог. Төслийн үйл ажиллагаатай холбогдон дагаж мөрдөх стандартуудыг дор жагсаав.

- MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт
- MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
- MNS 4943:2011 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
- MNS 3342:1982 Байгаль орчны хамгаалал, усан мандал. Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага
- MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
- MNS 4219:1994 Аж ахуйн нэгжүүдэд олгох экологийн паспорт. Үндсэн шаардлага
- MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээж авах, хадгалах, хамгаалах арга
- MNS (ISO) 5667-11:2000 Усны чанар. Дээж авах. Газар доорх уснаас дээж авах заавар
- MNS 0899:1992 Усан хангамжийн эх үүсвэрийг сонгох дүрэм ба шаардлага, эрүүл ахуйн шаардлага
- MNS 4047:88 Гадаргын усны чанарын шинжилгээний дүн
- MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- MNS 3298:1991 Хөрс. Дээж авах ерөнхий шаардлага
- MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт
- MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага
- MNS ISO 31000:2011 Эрсдэлийн менежмент зарчим ба заавар
- MNS5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин-утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга

- MNS5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин-утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга

Дээрх стандартуудын холбогдох заалтуудыг тайланд орчны бохирдлыг үнэлэх, шинжлэх, хянахад зориулж тодорхой оруулсан байна.

#### **Журам, аргачлал:**

- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам /Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт/
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хянан батлах, тайлагнах журам /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн А-05 дугаар тушаалын хавсралт/
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-04 дугаар тушаалын хавсралт/
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01-р сарын 06-ны өдрийн А-03 тоот тушаалын хавсралт/
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01-р сарын 10-ны өдрийн А-11 тоот тушаалын 2 дугаар хавсралт/
- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний аргачлал /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тушаалын 1-р хавсралт/
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах аргачлал /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А-117 тушаалын 1-р хавсралт/

Монгол улсаас КОВИД-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй хууль тогтоомж (2020 оны 04 сарын 29)

- КОВИД-19 корона вируст халдварт тахалтай тэмцэх, сэргийлэх, Нийгэм эдийн засгийн нөлөөг бууруулах тухай хууль
  - 13-р бүлэг. Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг
  - 12-р зүйл. Иргэний эрх, үүрэг
  - 13-р зүйл. Бизнесийн байгууллага, аж ахуй нэгний эрх, үүрэг

#### **Монгол Улсаас COVID19 цар тахлын эсрэг хэрэгжүүлж буй хууль тогтоомж**

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль (2020.04.29-нд батлагдсан)
  - Хуулийн гуравдугаар бүлэг иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг
  - 12 дугаар зүйл.иргэний эрх, үүрэг
  - 13 дугаар зүйл.аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

### 3. БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ БОЛОН БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

Төсөл нь зөвхөн физикийн бус үйл ажиллагааг (техникийн туслалцаа үзүүлэх, чадавхыг бэхжүүлэх, мэдээллийн технологийн систем дэх хөрөнгө оруулалтын дэмжлэг, статистикийн үйлдвэрлэлийн систем гэх мэт) дэмжин явуулах тул тэдгээр нь байгаль орчинд шууд нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна. Гэсэн хэдий ч засгийн газраас санхүүжүүлж буй DRC-ын төслийн хүрээнд зарим бага хэмжээний физик үйл ажиллагаанууд явагдах юм. Үүнд:

- 800 метр кабель ба түүнтэй холбоотой 186 метр шуудууг нэмж байршуулах
- Дэд станцын бетон суурь
- Жийргэвчийн хоёр бетон суурь
- Хөргөх цамхагт зориулсан бетон суурь
- Дотоод засал чимэглэлийг шинэчлэх/мэдээллийн технологийн тоног төхөөрөмж суурилуулах

Одоо ашиглаж буй ҮНДТ-ийн барилга нь Монгол Улсын дэд хотуудын нэг болох Улаанбаатар хотоос 220 км зайд орших Дархан-Уул аймгийн Дархан суманд байрладаг. Дархан-Уул аймаг нь Монгол Улсын хойд хэсэгт орших Хэнтийн нурууны дунд орших Хараа голын зүүн хойд хөндийд 327.5 мянган га талбайг эзэлдэг бөгөөд далайн түвшнээс дээш 707 м өндөрт харьцангуй нам өндөрт оршдог. Дархан сум нь Евразийн шилмүүст ой, нуга хээрийн бүс, Зүүн Азийн Орхон-Туулын нам дор уулын нуруунд оршдог. Төслийн талбайн ойролцоо 8 дэд овгийн 10 төрөлд хамаарах нийт 11 зүйл ургамал бүртгэгдсэн байна. Эдгээрээс хамгийн олон нь Үетэн овгийнх байна. Амьтны зүйлийн хувьд хөхтөн амьтад, мэрэгч амьтад, махчин амьтан, туурайт амьтад, шавьж, шувуу, туулай зонхилдог. Шувуудын хувьд тус улсын ихэнх зүйлийн шувууд байх буюу сойр, хөтүү, харцага, тоншуул, хөхөө, ятга шаазгай зэрэг зүйлийн шувуудтай. Одоогийн Дархан сум нь 18 багтай бөгөөд сумын ЗДТГ нь 103 албан хаагчтай бөгөөд иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхээр ажиллаж байна.

Байгалийн нэн чухал амьдрах орчин, хуулиар хамгаалагдсан соёлын өвийг оролцуулалгүйгээр энэхүү төслийн бүс нутаг хүний үйл ажиллагааны улмаас эрчимтэй нөлөөлөлд өртсөн.

ҮНДТ-ийн төслийн физик үйл ажиллагаанууд нь биологийн төрөл зүйл, соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж тооцож байна. Барилгын ажлын цар хүрээ, хэлбэрийг харгалзан үзээд төсөлд цөөн тооны ажилчдыг орон нутгаас татан оролцуулахаар төлөвлөж байна. Ажилчдын кемп, шилжилт хөдөлгөөн, замын хөдөлгөөнд ноцтой саад учруулахыг урьдчилан таамаглаагүй. Барилгын ажлын явцад хүрээлэн буй орчны болзошгүй нөлөөлөлд дуу чимээ, тоос шороо, тээврийн хэрэгслийн утаа, жижиг хог хаягдал үүсэх зэрэг орно. Эдгээр нөлөөлөл нь бага, түр зуурын, орон нутгийн шинжтэй байх төлөвтэй байгаа бөгөөд төсөлд сайн туршлагыг нэвтрүүлж багасгах боломжтой. ХАБЭА-н болзошгүй асуудлууд нь ихэвчлэн хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд юм. Ашиглалтын явцад хүрээлэн буй орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах үүднээс барилгын зураг төслийг боловсруулахдаа зохих агааржуулалт, хогийн сав, гэрэлтүүлэг, гал унтраагч, ариун цэврийн байгууламж гэх мэт чанарын стандартыг харгалзан үзнэ.

Дараах хүснэгтэд байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон холбогдох нөлөөллийг бууруулах арга хэмжээг нэгтгэн харуулав. Бага хэмжээний барилгын ажилд зориулсан байгаль орчны туршлагын дүрмийг<sup>1</sup> Хавсралт 1-т заасны дагуу бэлтгэсэн болно.

---

<sup>1</sup> Англи нэршил: Environmental Code of Practices (ECOP) for Small Scale Civil Works

<b>Болзошгүй нөлөөлөл</b>	<b>Бууруулах арга хэмжээ</b>	<b>Хариуцах</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа</b>
Цахилгаан шугам шинээр тавигдах болон хуучин шугам хоолойн барилга угсралтын, газар шорооны ажлын үед тоосжилт үүсэх	Усны машин ашиглан тоосжилт үүсэх боломжтой газруудыг дулааны улиралд услах, чийглэх	Төсөл хэрэгжүүлэгч болон гэрээлэгч тал	Бүтээн байгуулалтын үе
Шугам хоолойн засвар, үйлчилгээ, шинээр тавигдах шугам хоолойн барилга угсралтын газар шорооны ажлын улмаас хөрсөн бүрхэвч эвдрэх	Газрын талбайн хэмжээг аль болох бага байлгаж, тухайн газрыг аль болох хурдан тогтворжуулж, тухайн газар нутгаар ус зайлуулах хоолойг хянах	Төсөл хэрэгжүүлэгч болон гэрээлэгч тал	Бүтээн байгуулалтын үе
Шугам хоолойн бүрэн бүтэн байдал алдагдсанаас усны алдагдал үүсэх	Шугам хоолойн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж ажиллах	Төсөл хэрэгжүүлэгч болон гэрээлэгч тал	Бүтээн байгуулалтын үе
Хог хаягдлыг ил задгай хаяснаар орчны бохирдол үүсгэх	Хог хаягдлыг тогтоосон журмын дагуу кодлон ангилж дахин ашиглах, зайлуулах арга хэмжээг авах	Төсөл хэрэгжүүлэгч болон гэрээлэгч тал	Бүтээн байгуулалтын үе
Хог хаягдлыг ил задгай хаяснаас хөрс доройтох	Хог хаягдлыг нэг цэгт цуглуулан ангилж, битүү саванд хадгалан тогтмол хугацаанд тээвэрлэж байх	Төсөл хэрэгжүүлэгч	Бүтээн байгуулалтын үе
Тоног төхөөрөмж, машин механизмын хөдөлгүүрээс үүдэлтэй шуугиан ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	Техник, тоног төхөөрөмжийн шуугиан бууруулах арга хэмжээг авах	Төсөл хэрэгжүүлэгч болон гэрээлэгч тал	Бүтээн байгуулалтын үе
Орон нутгийн иргэдийн хөдөлгөөний аюулгүй байдал	Суваг шуудууг аль болох богино хугацаанд дүүргэх; Замын хөдөлгөөнийг чиглүүлэх анхааруулах тэмдэг байрлуулж, хөдөлгөөний аюулгүй байдлын ажилтныг томилох	Төслийг хэрэгжүүлэгч, гүйцэтгэгч	Бүтээн байгуулалтын үе
<b>Галын аюул</b> Аянга, цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах	-Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар дотоодын дүрэм, журам боловсруулж, түүнийг мөрдөн ажиллах, - Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах,	Төсөл хэрэгжүүлэгч	Бүтээн байгуулалтын болон үйл ажиллагааны үе

	байнгын бэлэн байлгах, галын аюул гарч болзошгүй газруудад анхааруулах хуудас, тэмдэг, тэмдэглэгээг тавих - Аянга зайлуулагчийг шаардлагатай бүх газруудад байрлуулах		
